

*“Хүн бүр бүх эрхээ эдлэх эрх чөлөөтэй байх ёстой.
Иргэний болон улс төрийн эрх, тэгээд эдийн засаг, нийгэм,
соёлын эрх хэмээн хүний эрхийг зэрэглэх ёсгүй”*

Хүнийг хүндэл!! **Эдийн засаг, нийгэм соёлын эрхээ** **хамгаалцгаая**

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

- Дэлхийд **963** сая хүн өлсөж байна
- **1** тэрбум хүн ядуусын хороололд амьдардаг
- **1,3** тэрбум хүн эрүүл мэндийн наад захын үйлчилгээ авах боломжгүй байдаг
- **2,5** тэрбум хүн ариун цэвэр, эрүүл ахуйн үндэс шаардлагыг хангагдаагүй орчинд амьдарч байна
- Жирэмсний хүндрэлийн улмаас хором тутам **1** эмэгтэй амь насаа алддаг
- Монгол улсад ядуурлын түвшин **35,2** хувь болсон бөгөөд **930,000** орчим хүн ядуу амьдарч байна.
- Өөрөөр хэлбэл **100** хүн тутмын **35** нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эрхээ хамгаалж тэмцэх цаг боллоо

Халдашгүй дархан, нэр төртэй байх эрх нь зөрчигдсөн хүнд нөхцөлд олон сая хүн амьдарч байна. Байгалийн гамшигт өртөөгүй хэрнээ хүмүүс өлсгөлөн, халдварт өвчинд нэрвэгдэн, орон гэргүй болж ядуурч байгаа билээ. Дэлхийн нөөц баялаг ч хүрэлцээтэй биш байна. Баян улс орнуудад ч зохистой орон байраар хангагдах, шаардлагатай эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгаа иргэд олон байдаг. Хэдийгээр засгийн газрууд нөөц бололцоо дутмаг байна хэмээн өгүүлэх боловч яг үнэндээ хүмүүсийг алагчлан, нийгмийн хүрээний гадна үлдээж байна.

Олон улсын хамтын нийгэмлэгээс тусгаар тогтносон улс орнуудын засгийн газар олон сая хүний эрхийг үл тоомсорлож байгааг хатуу анхааруулсан байна. Олон улсын санхүүгийн байгууллагууд ч эмзэг бүлгийнхэнд шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх, зохих түвшинд сурч боловсрох эрхийг нь хязгаарласан улс орнуудад тодорхой нөхцөлтэй арга хэмжээнүүдийг авдаг. Гэвч томоохон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх явцдаа олон сая хүнийг орон гэргүй болгон хохироож байна.

Засгийн газар хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлагаа заримдаа умартаж байна. Тэд байгаль орчин бохирдуулахыг зөвшөөрч, иргэдийн хөдөлмөр мөлжих явдлыг таслан зогсоолгүй үндэстэн дамнансан пүүс, корпорациудыг өөгшүүлж байна.

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн зөрчил нь нөөц баялаг, эдийн засгийн чадавхиас шалтгаалдаггүй гагцхүү, улс төрийн бодлогоос хамаардаг.



Эдийн засаг, нийгэм, со

Хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон иргэний, улс төрийн эрхтэй байдаг. Тухайлбал:

Хөдөлмөрлөх эрхтэй. Ялангуяа эвсэл холбоонд нэгдэх, байгуулах, гарах эрхтэй. Албадан буюу хүчээр хөдөлмөрлүүлэхээс хамгаалагдах, ажиллах аятай таатай нөхцлөөр хангуулах эрхтэй.

Сурч боловсрох эрхтэй. Анхан шатны боловсролыг үнэ төлбөргүй олгох, авьяас чадварыг харгалзан дээд боловсролыг хүн бүрт хүртээмжтэй болгох:

Уугуул иргэд болон үндэстний цөөнхийн соёлын эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих ёстой.



Нобелийн шагналт хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт эдлүүлэх зорилгоор кампанит үйл ажиллагаа явуулдаг хамгийн ардчилсан дэлхий нийтийн хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн юм.



Хэн хариуцлага хүлээх вэ

Улс орнуудын засгийн газар нь хүний эрхийг **хамгаалах** үүрэгтэй. Засгийн газрууд хүний эрхийг **хүндэтгэж**, түүнийг **зөрчихгүй байх** ёстой. Хэн нэгэн этгээд, нам, хүчнийхэн болон ажил олгогч байгууллагуудын эрх баригчид хүний эрхийн зөрчил гаргахгүй байх нөхцлийг Засгийн газар хангаснаар иргэдийнхээ эрхийг хамгаалах ёстой.

Засгийн газрууд нөөц бололцоо, эдийн засгийн чадавхийн хувьд харилцан өөр өөр байдаг. Олон улсын эрх зүйгээр эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг аажимаар бүрэн дүүрэн хангахыг хүлээн зөвшөөрдөг боловч эдгээр эрхийг хамгаалах, хүндэтгэх, алагчлалгүй тэгш эдлүүлэх боломжоор шууд хангах нь засгийн газруудын үүрэг юм. Нөөц бололцоо дутмаг байдал нь дээрх эрхийг эдлүүлэхгүй байлгах, үүнийгээ зөвтгөх зүйл биш юм.

Засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг иргэддээ эдлүүлэх зарим арга хэмжээг ухамсартайгаар авч хэрэгжүүлэхдээ нэн тэргүүнд хангах болон эрхээ эдлэх наад захын хэм хэмжээг анхаарах ёстой. Тухайлбал сурч боловсрох эрхээр хангахдаа анхан шатны боловсролыг заавал үнэ төлбөргүй олгох ёстой гэх мэт.

Засгийн газар бодлого боловсруулах, хууль тогтоох, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэхдээ алагчлахгүй бөгөөд нөөцийг байрлуулахдаа хамгийн эмзэг бүлгийнхнийг нэн тэргүүнд харгалзан үзнэ.

Соёлын эрх гэж юу вэ?

Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхтэй. Эрх тэгш байдлын үндсэн дээр хүн бүрт эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй олгоно.

Зохистой орон гэрээр хангагдах эрхтэй. Соёлын хувьд нийцсэн, оршин суух таатай нөхцлийг бүрдүүлсэн зохистой орон сууцтай байх буюу хэнийг ч хүчээр орон гэрээс нь хөөн гаргах ёсгүй.

Хүн бүр аюулгүй эрүүл хоол хүнсээр хангагдах эрхтэй. Өлсгөлөнгөөс ангид байж эрүүл аюулгүй, тэжээллэг хоол хүнсээр хангагдана.

Ундны цэвэр усаар хангагдах Дотоодын хэрэглээ болон бие махбоддоо хүрч болохуйц хүртээмжтэй аюулгүй, цэвэр ундны усыг хэрэглэх ёстой.

Эмнести Интернэшнл нь хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа явуулж, бодитой арга хэмжээ авдаг.

Эмнести Интернэшнл нь ямар нэгэн шашны сүсэг бишрэл эсвэл улс төрийн дарамт шахалтаас ангид биеэ даасан үйл ажиллагаа явуулдаг.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалах кампанит ажилд Олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нэгдлээ

Эмнести Интернэшнл байгууллага 40 гаруй жилийн турш хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд үүндээ дэлхийн өнцөг булан бүрийн олон сая хүнийг дайчлан хамруулсан билээ.

Үзэл санааны хоригдлуудаас илүү олон сая хүн ядуурал, өвчин зовлон, өлсгөлөнгийн улмаас хоригдол болж байна.

Эмнести Интернэшнлийн гишүүд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн төлөө тэмцэж буй хүний эрхийн байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллана.

Хүний эрх нь салшгүй зүйл бөгөөд хүний нэр төр хамгаалагдсан байх ёстой. Эмнести Интернэшнл хүн бүрийн бүх эрхийг хамгаалахын төлөө ажиллах болно.

Эмнести Интернэшнл байгууллагын амжилттай хэрэгжүүлсэн нэгэн кампанит ажил

2003 онд Мексикийн Сан Рафелийн иргэдийн орон гэр газар хөдлөлтийн улмаас сүйдсэн байна. Зохистой, шаардлага хангасан орон байраар хангаагүй эрх баригчдын талаар иргэд гомдол гарган, шинэ орон байраар хангуулах кампанит ажлыг өрнүүлжээ. Хүний эрхийн төлөө тэмцэгчид болон Эмнести Интернэшнлийн гишүүд захидал, уриалга гарган, тус улсын засгийн газарт шахалт үзүүлсний ачаар 2005 оны эхээр иргэдийг цэвэр усаар хангагдах боломжтой, шинэ газар нүүлгэн шилжүүлж, орон байраар хангасан байна.

Та юу хийж чадах вэ

Та Эмнестм Интернэшнл байгууллагын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах даян дэлхийн кампанит ажилд нэгдэнэ үү.

Та Эмнести Интернэшнл байгууллагын гишүүн болно уу. Ингэхийн тулд та өөрийн орон нутаг дахь Эмнести Интернэшнлийн салбарт ханд.

Та мөн цахим хуудсаар зочилж мэдээлэл авахын сацуу гишүүн ч болж болно.

Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44, 10 тоот
Утас/факс: 976-11-324705
Цахим хаяг: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn



Хүний эрх бодит амьдрал дээр

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг түгээн дэлгэрүүлэхэд хүний эрхийн чиглэлээр даян дэлхийг хамарсан кампанит ажил зохион явуулагчид ихээхэн чармайлт гарган ажиллаж байна.

Тэд эрх нь зөрчигдсөн зарим хувь болон бүлэг хүмүүсийн эрхийг хамгаалах, сэргээхэд тодорхой хэмжээний туршлага хуримтлуулж чадсан бөгөөд цаашид хүмүүст эрхийг нь мэдүүлэхэд анхаарлаа хандуулах нь чухал хэмээн үзэж байна.

Үндэсний болон олон улсын эрх зүйд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг сайтар тусгасан байдаг.

Орон нутгийн Нийгэм, соёл, эдийн засгийн эрхийн төв олон мянган иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлж байгааг эсэргүүцсэн гомдол гаргасан тул Нигерийн Лагост Дэлхийн банкны санхүүжилтээр цэвэр усны хоолой барих ажлыг 1998 онд зогсоосон байна.

Газар нутгийг нь усан боомт, далайн үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын компани булаан авахыг эсэргүүцсэн Никарагуагийн үндэсний цөөнхийн тэмцэл 2001 онд ялалтанд хүрсэн юм. Америкийн хүний эрхийн шүүх тэдгээр иргэдийн эрхийг хамгаалахыг засгийн газарт нь үүрэг болгосон байна.

Нийгмийн эрхийн асуудлаархи Европын хороо Португал улс нь хөдөлмөрлөх эрхийг зөрчиж боржигон чулууны үйлдвэрт аз туршсан, хүнд нөхцөлд бага насны хөвгүүдийг ажиллуулан, боловсрол эзэмшихэд нь саад учруулж, хүний эрхийг ноцтой зөрчиж байгааг олж тогтоосон байна.

Өмнөд Африкт хэрэгжүүлсэн кампанит ажлын үр дүнд ДОХ-ын эсрэг эм үйлдвэрлэдэг олон улсын кампаниудаас уг эмийг хямд үнээр эх орондоо үйлдвэрлэх зөвшөөрөл авч, баталгаагүй эм бэлдмэл хэрэглэх явдлыг таслан зогсоож чаджээ. Уг кампанит ажил нь шаардлага хангасан эм тариагаар үйлчлүүлэх нь хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхийн нэг хэсэг гэдгийг онцолсон үйл явдал болсон байна.





“Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр”-өөс

- Иргэдийн хамтран өмчлөх болон хэсгээр өмчлөх дундын өмчийн эрхийг хангах эрх зүйн хамгаалалтыг хүчтэй болгох, түүний дотор хувьцаа эзэмшигчдээс хувьцаат компаний үйл ажиллагаанд тавих хяналтыг бодитой болгох, бүх гишүүдийн хуралд оролцож шийдвэр гаргах, төлөөлөн удирдах зөвлөлтэй хариуцлага тооцох, ноогдол ашиг авах эрхээ бүрэн эдлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

- Мал аж ахуй эрхлэгчдээс мал сүргээ эрүүлжүүлэх, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлж боловсруулан зах зээлд гаргах, орлогоо нэмэгдүүлэхэд төрөөс онцлон анхаарч дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ.

- Орон гэргүй, тэнэмэл хүмүүс, өнчин, асрамжинд байгаа хүүхэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийнхэн, нэн ядуу хүмүүсийг орон сууцаар хангах зорилгоор хэрэгжүүлэх

үндэсний болон орон нутгийн сан байгуулж ашиглах, орон гэргүй тэнэмэл, нэн ядуу хүмүүст зориулан хооллох, хоноглох эрүүл мэндийн үйлчилгээ авах цэгүүд бий болгож, түүнд хүмүүнлэгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

- Хүрээлэн буй орчны бохирдлыг багасгаж, бохирдолыг зөвшөөрөгдсөнөөс хэтрүүлэхгүй хэмжээнд байлгах, хүнс, ундааны болон хэрэглээний ус, эм тарилга болон ахуйн хэрэглээний нэн тэргүүний хэрэгцээт бараа бүтээгдэхүүний аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангах, эдгээр хүрээнд тавих хяналтыг хүч, нөлөөтэй болгоно.

- Хот суурин газрын барилга, байгууламжийн аюулгүй байдлын стандартыг боловсруулж, түүний хэрэгжилт, хяналт шахалтыг хүчтэй болгоно.

ИРГЭН ТА - Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг хянахад хувь нэмрээ оруулж, санал хүсэлтээ манай байгууллагад ирүүлнэ үү.